

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
2020 ОНЫ 02 ДУГААР САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2020 оны 02 дугаар сарын 28-ны өдөр

Багануур дүүрэг


№	ҮНДЭСЛЭЛ	ХИЙСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ
1	2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.1	<p>“Мон–Энержи Консалт” ХХК-ийн Паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл магадлангаар хянагдаж дулаан хангамж, мэдээлэл холбооны ажлын зураг баталгаажсан. Ус хангамж ариутгах татуургын ажлын зурагт экспертээс авсан зөвлөмжийн дагуу нэмэлт өөрчлөлт хийж, баталгаажуулахаар бэлтгэж байна.</p> <p>Цахилгаан хангамжийн зураг төсөлтэй холбоотой техникийн нөхцөл авах хүсэлтийг БХБЯ нь 01/685 дугаартай албан бичгээр Эрчим хүчний яаманд хүргүүлээд байна.</p> <p>Паркийн батлагдсан ерөнхий төлөвлөгөөг “Мон–Энержи Консалт” ХХК нь Барилга хөгжлийн төвд 02 дугаар сарын 28-нд №01 дугаартай актаар хүлээлгэж өгөв.</p>	100%
2	<p>БҮТП-ийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/619 дүгээр захирамж</p>	<p>110х35 2х25000 кВт хүчин чадалтай дэд станцыг хөрөнгө оруулагчид танилцуулан Хуулийн зөвлөх С.Отгонбаатар, “МЕСЕС” ХХК-ийн удирдлага болон “Мон-энержи Консалт” ХХК-ийн Бизнес хөгжлийн захиралтай хамтын ажиллагааны гурвалсан гэрээ байгуулсан. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.</p>	100%
3	<p>Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/619 дүгээр захирамж</p>	<p>Паркийн “Үйлдвэрийн албан контор”-ын барилгын зураг төслийг гүйцэтгэгч “Нутаг Консалт” ХХК-д холбогдох бичиг баримтуудыг гарган, хангагч байгууллагуудаас техникийн нөхцөлийг авч, гадна шугам сүлжээний холболтын цэгийг заалган ажлын зургийг гүйцэтгэж, магадлалаар оруулахаар бэлтгэж байна.</p>	100%
4	<p>Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/619 дүгээр захирамж</p>	<p>“Санни трейд” ХХК-ийн гүйцэтгэсэн паркийн төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний батлагдсан тайланг парк 02 дугаар сарын 03-ны өдөр хүлээн авсан.</p>	100%
5	<p>УИХ-ын 36 дугаар тогтоол</p>	<p>Шинэ бүтээн байгуулалтын дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх санал боловсруулж НШУҮИГ-т хүргүүлсэн.</p>	100%
6	<p>БҮТП-ийн хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө</p>	<p>Парк - суралцагч байх, инновацич болох ажлын төлөвлөгөөнд нэмэлт заалтыг оруулан Газрын даргаар батлуулав.</p>	100%

7	БҮТП-ийн хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө	“Багануур тохижилт” ОНӨААТҮГ-т автомагистраль зам дагуух хамгаалалтын зурвасны мод усалгааны худгийн систем болон дүүргийн хог хаягдлын шинэ цэгийг ашиглахтай холбоотой зөвлөмжид оруулах судалгааны ажил дуусав.	80%
8		ШАУИС хамтын ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хамтран дүгнэх бэлтгэлийг ханган 3 дугаар сарын 10-нд цахимаар дүгнэхээр тохиролцов.	100%
9		Паркийн ахуйн болон үйлдвэрлэлийн хог, хаягдлын менежментийн өмнөх төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулан Газрын даргаар батлуулав.	100%
10	2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.2.3	Дэвшилтэд техник технологийн мэдээллийн санг бэлтгэх ажлыг зохион байгуулав.	100%
11	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/1054 дүгээр захирамж	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг ханган ажилласан ба “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т 2020 оны 2 дугаар сарын 28-ны байдлаар нийт 18 бичиг ирснээс хариутай бичиг 5, хариугүй бичиг 13, хариутай болон хариугүй бичгийн шийдвэрлэлт 100%, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 100%-тай байна. “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-аас 2020 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар яам, нийслэл, аж ахуйн нэгж, албан байгууллагуудад нийт 10 албан бичиг явуулсан байна.	100%
12	2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2.2.1	baganuur-itr.mn цахим хуудсанд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 10, цаг үеийн 20 мэдээг байршуулан баяжилтыг тогтмол хийж байна.	100%
13	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	- Нийслэлийн өмч ашиглалт, удирдлагийн газрын “Өмчийн бүртгэлийн программ”-д байгууллагын өмчийг шивж оруулсан. - Нийслэлийн аудитын газарт 2019 оны санхүүгийн баримт бичгийг хянуулахаар хүлээлгэн өгсөн.	100%
14	Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дугаар тушаал	Байгууллагын архивын ажлын үндсэн зааврын хүрээнд : - 2019 онд байгууллагын үйл ажиллагааны явцад үүсч хөтлөгдсөн хадгаламжийн нэгжийг хуваарийн дагуу албан хаагчдаас хүлээн авсан. - 2019 онд байгууллагын үйл ажиллагааны явцад үүсч хөтлөгдсөн захирамжлалын баримт бичгүүдийг archive.edoc программд оруулан, дүүргийн Архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэнд шалгуулахад бэлэн болсон.	80%
НЭМЭЛТ АЖИЛ			
15	Нийслэлийн Засаг даргын А/108 дугаар захирамжийн биелэлтийг zendmaal@gmail.com цахим хаягаар 7 хоног бүр хүргүүлж байна.		100%
16	Нийслэлийн Засаг даргын А/168 дугаар захирамжийн эхний биелэлтийг 02 дугаар сарын 21-ний өдөр НЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.		100%
17	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу мөн иргэд, олон нийтийн шинэ төрлийн корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх, дээд газраас гаргасан холбогдох тогтоол, шийдвэрийн		100%

	хэрэгжилтийг хангах үүднээс “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ нь Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Онцгой комисстой хамтран ажиллаж, зөвшилцсөн хуваарийн дагуу эргүүлийн ажилд хяналт тавьж, дүн мэдээг өгөгдсөн загварын дагуу боловсруулан нэгтгэж, орой бүр 21:00 цагт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Шуурхай штабт цахим шуудангаар хүргүүлэн тайлагнан ажиллаж байна. Мөн 02 дугаар сарын 21-27-ны өдрүүдийн эргүүлийн нэгдсэн мэдээг battsoojubcity@gmail.com цахим хаягаар хүргүүлсэн.	
18	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн баталсан хуваарийн дагуу Сар шинийн баярыг угтсан цэвэрлэгээг хийж тайланг “Багануур Үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 27 дугаартай албан бичгээр хүргүүлэв.	100%

ХЯНАСАН:

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч. ЭЛБЭГСАЙХАН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Laswit

Б. НОМИНЗУЛ